



Соёл Эрдэм

モンゴル文化教育大学

SOYOL ERDEM UNIVERSITY



2024.10. No.69

ХЭЛТЭЙ БОЛ ДАЛАВЧТАЙ



1 ОУЭШ ХУРАЛ



2 МЭДЭЭЛЭЛ



3 АХЛАХ СУРГУУЛЬ



4 ГАДААД ХАРИЛЦАА

Соёл Эрдэм дээд сургууль болон Оберин их сургуулийн хамтарсан 7 дахь удаагийн эрдэм шинжилгээний хурал

第7回国際学術シンポジウム

(モンゴルと日本—過去・現在・未来—社会、経済、教育、歴史、宗教、環境、観光について)

8月4日、モンゴル文化教育大学と桜美林大学の共催、在モンゴル日本国大使館の後援による「第7回国際学術シンポジウム」が、本大学所属のシリーンボラグ・ツーリストキャンプにて開催されました。日本とモンゴル両国の学者や研究者が参加し、興味深い論文が多数発表されました。日本からは、桜美林大学の畑山浩昭学長をはじめ11名の学者・教職員が出席しました。また、会場はウランバートル市内から63kmも離れた草原にもかかわらず、在モンゴル日本国大使館から井川原賢駐モンゴル特命全権大使ご夫妻や、伊藤頼子二等書記官らも参加し、シンポジウムを大いに盛り上げました。



井川原 賢
Igawa Masaru
駐モンゴル特命全権大使
Япон Улсаас Монгол Улсад суугаа
Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд



牧原 創一
Makihara Souichi
モンゴル文化教育大学理事長
桜美林大学名誉博士
УЗ-ийн дарга, Оберин их
сургуулийн хүндэт доктор



畑山浩昭
Hatakeyama Hiroaki
桜美林大学学長
Оберин их сургуулийн захирал



Олон улсын эрдэм шинжилгээний хурлын үеэр

国際学術シンポジウム風景

2024.08.04-ний өдөр Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд М.Игавахагагийн дэмжлэгтэйгээр, Соёл Эрдэм дээд сургууль болон Японы Оберин их сургууль хамтран зохион байгуулсан 7 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний бага хурлаа “Шилийн булаг” жуулчны баазад зохион байгууллаа. Энэхүү хуралд гадаад дотоодын эрдэмтэн судлаачид илтгэл хэлэлцүүлж санал бодлоо солилцов. Тус хуралд Япон улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Игавахар Масарү гэргийн хамт мөн Япон улсын элчин сайдын яамны II нарийн бичгийн дарга Ито Ёрико нар оролцсоныг онцлон тэмдэглэхэд таатай байна. Оберин сургуулийн захирал Хатаяма Хироаки тэргүүтэй 11 эрдэмтэн багш Японоос ирж оролцон эрдэм шинжилгээний илтгэлээ хэлэлцүүлэв.



Олон улсын эрдэм шинжилгээний хурлын төлөөлөгчид
国際学術シンポジウム参加者記念写真

Японы Комазава охидын их сургуулийн багш оюутнууд Соёл Эрдэм дээд сургуульд зочлов

駒沢女子大学の教職員・学生が本学を訪問

2024年9月2日、駒沢女子大学の臼井実穂子教授、矢尻和範教育研究センター副所長および11名の学生が本学を訪問し、本学理事長や教員らと会談しました。会談では、駒沢女子大学や日本文化について紹介が行われました。また、モンゴルと日本の学生同士の面会も行われ、実りある文化交流となりました。

2024.09.02-ны өдөр Японы Комазава охидын их сургуулийн багш Үсүй Минэко, Яжири Казунори болон тус сургуулийн 11 оюутан Соёл Эрдэм дээд сургуульд хүрэлцэн ирж, бидний үйл ажиллагаатай танилцан, сургуулийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд цаашид хамтран ажиллах санал солилцож, оюутан сурагчидтай уулзан, Япон орны тухай болон Комазава их сургуулийн танилцуулгыг хийж, оюутан залуус хоорондоо найрсаг хөгжилтэй нэг өдрийг өнгөрүүлээ.



Комазава их сургууль болон Соёл Эрдэм дээд сургуулийн багш оюутнуудын хамт
駒沢女子大学とモンゴル文化教育大学の学生・教職員の記念写真

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ “БОЛОВСРОЛЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” ЦОЛ ТЭМДЭГЭЭР МАНАЙ БАГШ ШАГНУУЛЛАА

М.ムンフツェツェグ日本語学科主任が モンゴル国文部科学省教育功労章を受章

Би Соёл Эрдэм дээд сургуулийн Япон судлалын тэнхмийн эрхлэгч М.Мөнхцэцэг байна. Боловсролын салбарт 16 дахь жилдээ ажиллаж байна. Сургуульдаа багш, сургалтын алба, тэнхмийн эрхлэгч гээд ажил албанд томилогдон ажилласаар эдүгээ 11 дэх жилээ үдсэн байна. Манай хамт олон нөхөрсөг, найрсаг бие биедээ түшиг тулгууртай аливаа ажлыг хийх хүсэл эрмэлзэл дүүрэн хамт олон. Ийнхүү Монголын багш нарын баярын 58 дахь өдөр, Дэлхийн багш нарын баярын 30 дахь өдрийн баяраар Монгол улсын Засгийн газрын шагнал “Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнуулсандаа чин сэтгэлээсээ талархаж байна. Сургуулийнхаа нийт хамт олонд баярын мэнд хүргэе. Цаашид улам бүр хичээн ажиллах болно. Та бүхэндээ баярлалаа.

Япон судлалын тэнхмийн эрхлэгч
М.Мөнхцэцэг



НЭМЭЛТ ЭЛСЭЛТ АВЧ БАЙНА



QR код уншуулаад
Соёл Эрдэм дээд сургуулийн
МАГИСТР-ын нэмэлт
элсэлтэд бүртгүүлнэ үү



QR код уншуулаад
Соёл Эрдэм дээд сургуулийн
БАКАЛАВР-ын нэмэлт
элсэлтэд бүртгүүлнэ үү

НАМРЫН ЯВГАН АЯЛАЛ

秋のハイキング



2024-2025 оны хичээлийн шинэ жил эхлээд нэг сарын хугацаа өнгөрч, намрын шар нар ээсэн дулаан өдрүүд үргэлжилсээр байна.

Манай сургуулийн уламжлал болсон намрын явган аялал маань 10 сарын 5-ны бямба гарагт болж, оюутнууд маань шинээр элссэн нэгдүгээр курсын дүү нараа дагуулаад намрын явган аялалаа хоорондоо танилцах, байгаль дэлхийгээ хамгаалах, эрүүл агаар амьсгалах зорилготойгоор зохион байгууллаа.

2024-2025 оны хичээлийн жилд сургуулиа төгсөх 4-р курсийн оюутнуудынхаа төгсөлтийн ажил, анги дэвшсэн болон 1-р курсийн шинэхэн оюутнууддаа цаашдынх нь сурлага хөдөлмөрт өндөр амжилт хүсье.

2024~2025学年度が始まってから1ヶ月が経ち、秋の温暖な日が続いています。

本校の伝統的な行事である「秋のハイキング」が、10月5日（土曜日）に開催されました。学生たちは新入生を連れて、お互いを知り、環境を守りながら、有意義な時間を過ごしました。

2024-2025学年度に卒業する4年生の皆さんのご卒業と、進級した全ての学生、新1年生の今後の学びに心よりお祈り申し上げます。皆さん、これからも頑張ってください。

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ИРЭЭДҮЙ: ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЭРИН ҮЕИЙН ХУВЬСАЛ 高等教育の未来：人工知能時代の進化



Маркетинг дэд захирал **Б. Ариунболд**
(Соёл Эрдэм сургуулийн маркетинг дэд захирал, дээд боловсролын салбарт 11 жил ажилласан, АНУ болон БНХАУ-д боловсрол эзэмшсэн. БНХАУ-ын Лиаонин мужийн их сургуулийн Олон улсын сургууль, 1+3 Олон улсын сургалтын институтэд багшаар ажиллаж байсан.)

байгууллагуудад асар олон мянган ажилтныг хамарсан хүний нөөцийн хямралын асуудал бий болж эхэлжээ. Ингээд, хүний орон зайг хиймэл оюун ухаан нөхөх болсон өнөө үед, ирээдүйн боловсон хүчнийг бий болгодог их дээд сургуулиуд технологийн хурдацтай хөгжилд ч мөн дасан зохицож сургалтынхаа үйл ажиллагааны нэг хэсэг болгох зайлшгүй шаардлага үүсээд байна.

Соёл Эрдэм дээд сургуулийн хувьд боловсролын орчин дахь технологийн өөрчлөлтүүд, эерэг ба сөрөг нөлөөллийг анзаарч, оюутнуудаа дижитал чадвартай, хариуцлагатай, бүтээлч иргэн болгоход чиглэн ажилладаг. IT Компьютер программ хангамжийн тусгай сургалттай институтийн хувьд тус сургууль

шинэ эрин үеийн боловсролд хувь нэмрээ оруулах зорилгоор, өргөн хүрээний шинэлэг стратеги баримталж байна. Шинэ эриний боловсрол гэж тэгвэл яг юуг яриад байна?

Хиймэл оюун ухааны хурдацтай өсөлт ба боловсролд үзүүлэх үр дагавар

Хиймэл оюун ухаан гэдэг зүйл хэрэглээ болоод нэлээд хэдэн жил болчихлоо. Технологийн насжилтаар бол хэдэн арван жил болчихсон л гэсэн үг. Орчин үеийн хүн бүр өнөөдөр нүдэнд үл үзэгдэх тоо тоймгүй олон программ хангамжийн томьёололд тооцооллын дунд амьдарч байна. Хөгжингүй орны бараг бүх салбарт хиймэл оюун ашиглаад эхэлчхэж, боловсролын салбар ч ялгаагүй. Их дээд сургуулийн хувьд ч гэсэн хиймэл оюун ухаанаар ажилладаг хэрэгслүүдийн тусламжтайгаар сургалтын үр дүнг хэмжиж, сайн туршлага, сургалтын баяжуулалт, захиргааны үйл явцыг оновчтой болгож, сургууль завсардалт үүсэх эрсдэлийг урьдчилан таамаглах замаар оюутанд үлдэгдэл боловсрол олгох боломжтой болсон.

Багш хүний хувьд технологийн дэвшилийг хүлээн авах, сургалтын хөтөлбөрт оруулах, оюутнаа туршлагажуулах, ирээдүйн ажил олгогчдын шаардах ур чадварыг эзэмшүүлэхэд анхаарах ёстой гэж би үздэг. Технологийн хувьсал сурах үйл явцыг задалж, сургалтыг зөвхөн анги тэнхим, ширээ самбар, хичээлийн цагаар хязгаарлагдахгүй болгосныг ч хэлэхэд илүүц биз.

Технологид суурилсан энэ их хурдацтай хөгжил нь боловсролын салбарт зарим сорилтуудыг авчирсаар... Оюутнууд зөвхөн технологийн мэдлэгтэй төдийгүй шүүмжлэлтэй сэтгэдэг, асуудал шийддэг, багаар ажиллах чадвартай, хиймэл оюун ухааныг ашиглахдаа ч ёс суртахуунтай байх ёстой.

Их дээд сургуулийн үүрэг

Уламжлалт ойлголтоор бол их дээд сургуулийг ирээдүйн карьерын замд бэлтгэхийн тулд мэдлэг олж авдаг газар гэж үздэг. Тодорхой салбарт ажиллах нарийн мэргэжлийг ахисан шатны боловсролын хамт олж авдаг байгууллага бол яах аргагүй их дээд сургууль. Гэтэл технологийн хурдацтай хөгжил, өөрчлөлт салбар бүрд нөлөөлж дадал болсон уламжлалыг эвдсээр байна. Жишээ нь оюутныг нэгдүгээр курст ороход хэрэглэгдэж байсан зарим мэдлэг мэдээлэл, ажил хийх арга барил төгсөөд гарахад нь хоцрогдох магадлал ч байгаа.

Яг энэ талаар Соёл Эрдэм дээд сургуулийн удирдлагууд ч анхаарч, уян хатан сургалтын арга барил, хиймэл оюун ухаан, дижитал чадварт суурилсан бүтээлч ажлуудыг оюутнууддаа санал болгодог. Эрдмийн аялал бол нэг чигээрээ урсаад явдаг статик зүйл биш, баяжуулж төгөлдөржүүлж байдаг динамик өөрчлөлт гэж би багш хүний хувьд боддог. Манай сургуулийн хувьд ахлах ангиа дөнгөж төгсөөд ирж байгаа эсвэл мэргэжлийн ур чадвараа ахиулах хүсэлтэй байгаа эсэхээс үл хамааран боловсролын илүү хүртээмжтэй үйл ажиллагаа явуулсаар 30 гаруй жил ардаа үджээ. Цаашид ч бид хиймэл оюун ухаан гэх мэт хурдацтай хөгжиж буй технологийн орчин төвөггүй дасан зохицох чадвартай боловсон хүчин гаргах, илүү технологийн мэдлэгтэй, нийгмийн хариуцлагатай боловсон хүчин бэлдэж ажиллана.

Эцсийн дүндээ дээд боловсрол нийгэмтэй, технологитой зэрэгцэн хөгжих ёстой. Энэхүү өөрчлөлтийн цөм нь, аль ч улсад их дээд сургууль байдаг. Миний хувьд, боловсролын салбарт өчүүхэн ч гэсэн утга учиртай өөрчлөлтөд хувь нэмрээ оруулж, эх орныхоо ирээдүйд дусал ч гэсэн нэмэр болж буй маань нэр төрийг хэрэг гэж боддог.

МОНГОЛЫН ОРЧУУЛАГЧДЫН АНХДУГААР ЧУУЛГАН ТӨРИЙН ОРДОНД БОЛОО

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулж буй Монголын Орчуулагчдын анхдугаар чуулган 9 дүгээр сарын 30-ны өдөр Төрийн ордонд боллоо.



9月30日、オフナー・フレルスフ大統領の後援のもと、モンゴル翻訳者・通訳者全国フォーラムが政府庁舎で開催され、モンゴル文化教育大学の教員3名が参加しました。フォーラムの冒頭、Ch. ロドイラブサル大統領教育・科学・技術顧問がオフナー・フレルスフ大統領の挨拶を伝えました。

「現在、モンゴルの外交政策や国際関係はますます拡大し、歴史的な国賓訪問が成功裏に実施されています。モンゴルの豊かな歴史や

誇り高い文化、偉大な遺産が世界に向けて発信されている中で、翻訳者や通訳者の知識や技術、鋭い感覚、誠実な姿勢、責任感がますます重要視されています」と述べました。

また、大統領は、フォーラムの参加者が翻訳分野が直面する課題、翻訳者・通訳者の専門技術、翻訳作品の質と基準の評価、国際的なデジタル翻訳や人工知能による翻訳の動向、モンゴルの発展レベルなどを議論し、翻訳分野の発展に向けた解決策を探り、今後の目標

Тус чуулганы оролцогчдод хандаж Ерөнхийлөгч У.Хүрэлсүх мэндчилгээ дэвшүүлснийг Ерөнхийлөгчийн Боловсрол, шинжлэх ухаан, технологийн бодлогын зөвлөх Ч.Лодойравсал уншиж танилцуулсан юм.

Тэрбээр Ерөнхийлөгч нийт оролцогчдод хандаж Олон улсын орчуулагчдын өдрийн мэндийг дэвшүүлснийг уламжилсны зэрэгцээ эдүгээ манай улсын гадаад бодлого, гадаад харилцаа улам өргөжин бэхжиж, түүхэнд тодоор бичигдэн үлдэх төрийн айлчлалуудыг амжилттай зохион байгуулж, монголчууд бидний баялаг түүх, бахдам соёл, суу алдрыг дэлхий дахинд сурталчлан таниулж буй энэ цаг үед хэлмэрч, орчуулагчдын мэдлэг чадвар, торгон мэдрэмж, туйлбартай зан, үүрэг хариуцлага илүү чухал болж байна хэмээн

тэмдэглэв.

Түүнчлэн уг чуулганы үеэр орчуулгын салбарын тулгамдсан асуудал, орчуулагч, хэлмэрч мэргэжилтний ур чадвар, орчуулгын бүтээлийн чанар, стандартыг үнэлэн дүгнэж, олон улсын цахим орчуулга, хиймэл оюуны орчуулгын чиг хандлага, манай улсын хөгжүүлэлтийн түвшнийг хэлэлцэн, орчуулгын салбарын хөгжлийн шийдлээ зураглан, цаашдын зорилго, хүний нөөцийн бодлогыг тодорхойлно гэдэгт итгэл төгс байна гээд, чуулганы үйл ажиллагаанд амжилт хүссэн болохыг хэллээ.

Боловсролын сайд П.Наранбаяр энэ үеэр хэлэхдээ “Орчуулагч нь тухайн зохиогчийн юу бодож зорьж байгааг сайтар ойлгосон байхын зэрэгцээ цаана нь буй соёл уламжлал, нийгмийн баримжааг ухаарсны үндсэн дээр сайн орчуулга

や人材管理政策を確立することに自信を示し、フォーラムの成功を祈念しました。

P. Наранбаяр 文化大臣は挨拶で、「翻訳者は、著者が何を考え、何を目標としているかをしっかりと理解し、その背景にある文化や社会情勢を把握した上で、質の高い翻訳を行う必要があります。これは著者と翻訳者が共に抱える課題であり、バランスを保ちながらその原則を守るかどうかを試される競争でもあります。二つの大きな世界を融合させ、バラ

хийдэг。Энэ нь эх зохиогч үндсэн орчуулагч хоёрын чадвар чансааны асуудал мөн бөгөөд тэнцвэртэйг байх зарчмыг хангаж буй эсэхийг харуулсан өрсөлдөөн юм。Энэ нь хоёр том ертөнцийг уусган нийлүүлэх тэнцүү ойлголт руу чиглэдэг билээ” гэв。

Чуулганаар “Уран зохиолын орчуулгын тулгамдсан асуудал”, “Орчуулагч, хэлмэрчийн мэргэжлийн ур чадвар, “Орчуулгын чанар стандарт, холбоо товчоод”, “Орчуулгын сургалт, нэр томьёо”, “Хиймэл оюун, цахим орчуулга”, “Тогтвортой хөгжил, гадаад харилцаа: Хам цагийн хэлмэрч, орчуулагчдын ёс зүйн хүс хэмжээ” зэрэг илтгэлийг хэлэлцүүлэв。Тус чуулганы өмнө урьдчилсан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан ба өнөөдрийн чуулганаас зөвлөмж гаргав。

ンスの取れた理解へと導くものです」と述べました。

フォーラムでは、「文学翻訳に直面する問題」、「翻訳者と通訳者の専門スキル」、「翻訳作品の品質と基準」、「翻訳・通訳者育成教育と用語」、「人工知能とデジタル翻訳」、「持続可能な開発と外交関係：同時通訳者と翻訳者の倫理基準」といったテーマでそれぞれ発表が行われました。

2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО

2024-2025年度の新学期が始まりました

Хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаанд Соёл Эрдэм ахлах, дээд сургуулийн багш нар, ажилчид, оюутан сурагчид, эцэг эхийн төлөөлөл оролцлоо. Нээлтийн арга хэмжээнд тус сургуулийн үүсгэн байгуулагч Макихара Соичи баяр хүргэж үг хэлсэн төдийгүй сурагчдын урлагийн тоглолт болж хичээлийн шинэ жилийн эхний хичээлийн хонх цохисноор сурагчид баяр хөөртэйгээр хичээлдээ орлоо.



モンゴル文化教育大学およびモンゴル文化教育附属高等学校の教職員、生徒、保護者の代表が2024-2025年度の新学期始業式に参加しました。始業式では、牧原創一理事長の祝辞と生徒たちによる演奏が行われ、新年度最初の授業の鐘が鳴ると同時に、皆が喜びをもって授業に臨みました。

БАГШ МИНИЙ БАХАРХАЛ

教師は私の誇り



2024-2025 оны хичээлийн жилд Монгол Япон улсын хөгжил соёл боловсролын салбарт түүчээлэн ажиллаж буй Соёл Эрдэм ахлах сургуулийн эрдэмтэн багш нартай мөр зэрэгцэн суралцагчийн эзэмших чадамжийг дээшлүүлэн хичээл сургалтын үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулан ажиллах болсондоо сэтгэл хангалуун байна.

Соёл Эрдэм Ахлах сургуулийн
Газар зүйн багш П.Нанзайбаатар

2024から2025年の学年度に日本国とモンゴル文化交流の発展、教育分野の先駆者であるモンゴル文化教育大学付属高等学校の教授、教師陣と御一緒にさせて頂き、教育質の向上に協力する事となりました事は、大変嬉しく思います。

文化教育高校地理担当
P. ナンザイバートル

МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ГОЛОМТ НИЙСЛЭЛ УЛААНБААТАРТ СУРАЛЦАЖ БАЙГАА НЬ АЗ ЖАРГАЛТАЙ БАЙНА

モンゴル民族の中心であるウランバートル首都で勉強ができた幸せ

Намайг Тамир гэдэг. Би Өвөр Монголын Шилийн гол аймгийн Зүүн Сөнид хошууны дунд сургуулиас Соёл Эрдэм ахлах сургуулийн ахлах ангид суралцахаар ирсэндээ маш их баяртай байна. Монголд ирээд үе тэнгийн найз нөхөдтэй болоод монгол хэл, Япон хэлийг хамтдаа сурч байгаа нь сайхан байна.

Монголын цаг агаар , монгол хүүхдүүдийн найрсаг, тусархаг, хичээнгүй зан чанар надад маш их таалагдаж, ирээдүйн хүсэл мөрөөдлөө биелүүлэх үйл хэрэгтээ шамдан суралцах болно. Баярлалаа

Соёл Эрдэм ахлах сургуулийн
10а ангийн сурагч Б. Тамир



私の名前はタミルです。私は内モンゴル自治区シリーンゴル盟の東スズデにある中等学校からモンゴル文化教育大学付属高等学校に留学できたことをとても嬉しく思っています。モンゴルに来て、同じ年齢の友達ができ、一緒にモンゴル語と日本語を学べることは嬉しいことです。モンゴルの気候と、モンゴルの子供たちのフレンドリーで親切的な性格、また勤勉さがとても気に入りました。将来の夢を実現するために一生懸命勉強します。ありがとうございます。

高等学校 1年生 タミル

ОЮУТАН Б.БАЯНБИЛЭГ ТОКИВА ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАХААР МОРДЛОО

常磐大学にB・バヤンビレグが奨学金特待生留学

Соёл Эрдэм дээд сургуулийн Гадаад хэл орчуулгын 2 дугаар курсийн оюутан Б.Баянбилэг нь 2024-2025 оны хичээлийн жилд Япон улсын Токива их сургуулийн сургалтын төлбөрөөс 100% чөлөөлөгдөж, мөн сар бүр 10,000 иений тэтгэлэг авах нөхцөлөөр Япон улсад суралцахаар болж, 2024 оны 09 сарын 10-ны өдөр Япон улсыг зорьсон билээ. Б.Баянбилэгийнхээ цаашдын хичээл сурлагад нь өндөр их амжилтыг хүсэн ерөөе.



モンゴル文化教育大学日本語通訳翻訳学科の2年生、B・バヤンビレグ君が常磐大学に留学することが決まり、2024年9月10日に日本へ出発しました。B・バヤンビレグ君の常磐大学での学費は100%免除され、さらに毎月10,000円の奨学金が支給されます。日本での勉強は時に挑戦を伴うかもしれませんが、その一つ一つが彼を成長させる貴重な経験です。新しい知識や文化を吸収し、友人や先生との交流を大切にしてください。目標に向かって勉強に励み、充実した留学生活を送ることを心から願っています。

АХЛАХ СУРГУУЛЬ 3

ЈЛРТ ЈАПОН ХЭЛНИЙ ТҮВШИН ТОГТООХ ШАЛГАЛТАНД СУРАГЧИД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

JLPT日本語能力試験結果発表

Япон хэлний түвшин тогтоох шалгалтын хариуг албан ёсоор хүлээн авлаа. 2024 оны 7-р сард болсон JLPT-ийн үр дүнг танилцуулъя! JLPT N3 түвшинд 1 сурагч, JLPT N4 түвшинд 3 сурагч, JLPT N5 түвшинд 10 сурагч тэнцсэн амжилттай байлаа. Хичээлийн 1 жилийн богинохон хугацаа хэдий ч сурагчдын минь хичээл зүтгэлийн үр дүнгийн илрэл билээ. Багш нар маань ч бас бүтээлч санаачлагатай ажиллаж, сурагчдынхаа сурах хүсэл эрмэлзлийг дээшлүүлж байгаад бид баяртай байна.

Тэнцсэн сурагчдаа халуун баяр хүргэе



日本語能力試験の結果が通知されました。2024年7月に実施されたJLPTの結果を発表します！ N3合格者1名、N4合格者3名、N5合格者10名でした。9ヶ月という短期間ででありながら、生徒たちの努力が実を結ぶ結果となりました。また、先生方も創意工夫を凝らし、生徒たちの学習意欲を向上させたことは大変喜ばしいことです。合格した皆さん、おめでとうございます！



- Б.Мөнгөлөн N3 түвшин /11а анги/
- М.Халиун N4 түвшин /12а анги/
- Б.Мөнхтүвшин N4 түвшин /12а анги/
- Б.Саранцацрал N4 түвшин /11а анги/
- Г.Алтанцхоож N5 түвшин /12а анги/
- Г.Ариунзаяа N5 түвшин /12а анги/
- Б.Анужин N5 түвшин /12а анги/
- Н.Амирлан N5 түвшин /11а анги/
- Д.Батцэцэг N5 түвшин /11а анги/
- С.Дөлгөөн N5 түвшин /11а анги/
- Б.Мишээл N5 түвшин /11а анги/
- Т.Оюунбилэг N5 түвшин /11а анги/
- Э.Цэлмэг N5 түвшин /11а анги/
- У.Хүслэн N5 түвшин /11а анги/


- Мунглен N3レベル合格/高校2年生/
- ハリュン N4レベル合格/高校3年生/
- ムンフトゥブシン N4レベル合格/高校3年生/
- サランツァツァラル N4レベル合格/高校2年生/
- アルタンツォージ N5レベル合格/高校3年生/
- アリウンザヤ N5レベル合格/高校3年生/
- アノジン N5レベル合格/高校3年生/
- アミルラン N5レベル合格/高校2年生/
- バットツェツェグ N5レベル合格/高校2年生/
- ドゥルグーン N5レベル合格/高校2年生/
- ミシェール N5レベル合格/高校2年生/
- オユンビレグ N5レベル合格/高校2年生/
- ツェルメグ N5レベル合格/高校2年生/
- フセレン N5レベル合格/高校2年生/

СУРАГЧИЙН НЭГ ӨДӨР

生徒による臨時教師・生徒の一日

Багш нарын баярын өдрийг тохиолдуулан ахлах сургуулийн 12-р ангийн сурагчид “Сурагчийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгуулж сурагчид маань нэг өдөр захирал, менежер багш нарын ажлыг орлон гүйцэтгэлээ. Сургуулийн захирал, сургалтын менежер болон мэргэжлийн хичээлийн багш нар ч бас сурагч болон “Хирагана” үсгийг унших, бичих аргад суралцан, үсэг цээжлэх картан тоглоомоор тоглолоо.

教師の日を記念して、高校12年生の生徒が「生徒の日」というイベントを企画し、高校3年生の生徒が校長やマネージャー、各科目の教師の仕事を1日演じました。校長やマネージャー、先生方も生徒の代わりに学習者として「ひらがな」の読み書きを勉強し、文字を覚えるカードゲームで遊びました。



Сурагч захирал
Б.Анунгоо
校長先生担当
のアノンゴ



Суралтын менежер
Э.Энхдөлгөөн
教頭先生担当の
エンヘドゥルグーン

Сурагч багш нар

各科目を担当した生徒



Сурагч багш Т.Төрболд математикийн
хичээл зааж байгаа нь
トゥルボルドの数学の授業



Сурагч багш Р.Билгүүндалай 10-р ангид биологийн
хичээл зааж байгаа нь
ビレグーンダライの生物の授業



Багш нар Хирагана үсгийн картаар тоглож байгаа нь
先生方がひらがなのカードゲームに夢中



Бэлэг солилцоо
教師と教師生徒との記念品交換



АХА тэмцээний аварга 11а ангийн сурагч Б.Оюунбилэг, С.Дөлгөөн
クイズ大会優勝者オユンビレグ及びドゥルグーン

“CAL” ХХК-НЫ ТАНИЛЦУУЛГА СЕМИНАР

株式会社CALがモンゴル文化教育大学で説明会を開催

CAL (Challenge And Lead) ХХК болон манай Соёл Эрдэм дээд сургууль нь Программ хангамж, Мэдээллийн систем хөтөлбөрөөр төгсөгчдийг Япон улсад ИТ чиглэлээр үндсэн ажилтнаар ажиллах болон Япон хэлний хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр 2024 оны 07-р сарын 4-ний өдөр хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

Энэхүү хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 10 дугаар сарын 1-ний өдөр CAL ХХК нь манай сургуульд ирэх Програмын хангамжийн ангийн оюутнуудад танилцуулга уулзалт хийж, зөвлөгөө мэдээлэл өглөө.



左から岩本健吾海外企画事業部部長、牧原理事長
東京にて 6月

キャル株式会社とモンゴル文化教育大学は、2024年7月4日にソフトウェアおよび情報システム・プログラムの卒業生が日本でIT関連の正社員として働くための共同日本語プログラムを実施する協力協定を締結しました。その協力協定の一環として、株式会社CALは10月1日に説明会を開催し、本学のコンピュータープログラム学科の学生たちに向けて、会社の紹介や日本での就職に関するアドバイス、情報提供を行いました。


ЯПОН УЛСЫН ВВИ
БАЙГУУЛЛАГЫН ШУГАМААР ИРСЭН
ЯПОН БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

日本語教師の感想 (BBI日本語教師海外派遣プログラム)

これから1ヶ月間、お世話になります、浅川克之です。私は東京で生まれ、育ちました。外国の方が持つ日本のイメージは、新宿や渋谷のような人の多い街かもしれません。そこはとても賑やかで便利な場所ですが、住んでいる人は少ないです。私が住む町は、大きな川が流れ、近くにはいくつかの小さな山があります。木々が多い公園も多く、山には狸や狐、猪が暮らしています。私の町も東京にあります。西の多摩地区は、とても静かで住みやすいところです。

これまで私は、就職情報を学生に提供する会社で30年以上働いてきました。その仕事をしている中で、日本語教師という仕事を知りました。定年退職を機に資格を取得し、昨年から日本語学校で授業をしています。そこにはモンゴルからの留学生が何人もいます。正直、モンゴルという国については、相撲力士の出身国というくらいイメージしかありませんでした。ですが、大きな体から受ける印象とは異なり、おおらかでとても温厚な性格の学生たちでした。また、日本語とモンゴル語が似ていることを知り、さらに興味が湧きました。そして、モンゴルで日本語を学んでいる人たちと直接話してみたい、と強く思うようになりました。日本は現在、高齢化が進んでおり、どこへ行っても高齢者が多いです。モンゴルに来て最も驚いたのは、子どもたちがたくさん遊んでいることです。私が子どもだった頃の日本を思い出しました。まだ数日しか授業をしていませんが、学生たちはみんな熱心に話をしてくれます。日本人として、学生が日本語に興味を持ってくれるのはとても嬉しいことです。日本に興味を持ってくれた人との理解が深まれば、人も国ももっと近づけると 생각합니다。今後は、アジアの日本語教育を支援する存在になりたいと考えています。これからのモンゴルでの生活も楽しみです。短い期間ですが、どうぞよろしくお願いします。

以上



Намайг Асакава Кацүюки гэдэг. Би Соёл Эрдэм дээд сургуульд 1 сарын хугацаанд Япон хэл заана. Японы Токио хотод төрж өссөн. Гадаад хүмүүсийн хувьд Та Япон улсыг юуаар төсөөлдөг вэ? гэвэл мэдээж Шинжюкү, Шибүяа гэх хүн олон байж магадгүй. Тэдгээр газруудад бол хүн бараг амьдардаггүй маш хөл хөдөлгөөн чимээ шуугиан ихтэй. Миний амьдардаг газар бол урсгал том голтой, ойролцоо нь намхан уул хэд хэд байдаг. Модтой цэцэрлэгт хүрээлэн их олон байдаг бөгөөд ууланд элбэнх, үнэг, зэрлэг гахай байдаг.

Манай хот ч бас Токиод байдаг. Токио хотын баруун дүүрэг болох Тама нь маш нам гүмхэн амьдрахад их таатай байдаг. Өнөөг хүртэл би оюутнуудад ажлын байрны талаар мэдээлэл өгдөг компанид 30 гаруй жил ажиллаж байна. Тэгээд энэхүү ажлын ачаар би Япон хэлний багш гэдэг ажлыг олж мэдсэн. Тэтгэвэртээ гараад энэ мэргэжлийг эзэмшин өнгөрсөн жилээс Япон хэлний сургуульд Япон хэл зааж байна. Тэр сургуульд Монголоос ирсэн оюутнууд цөөнгүй байсан. Яг үнэнийг хэлэхэд Монгол гэдэг орны тухай хүчтэй том биетэй Сүмо бөх төдий л мэддэг байсан. Гэвч тэрхүү төсөөллөөс огт өөр байсан бөгөөд Монгол оюутнууд халуун дулаан сэтгэлтэй байсан. Мөн Япон хэл болон Монгол хэлний жил төстэй байдлыг олж мэдээд улам бүр сонирхол төрөх болсон. Тийнхүү Монголд Япон хэл сурч байгаа оюутнуудад шууд Япон хэлийг зааж ярилцаж үзмээр санагдсан.

Японд өдийд өндөр настан ихтэй нийгмийн үс бөгөөд хаана ч очсон настай хүмүүс ихтэй. Монголд ирээд хамгийн их гайхсан зүйл гэвэл хүүхдүүд маш ихээр тоглолдон гүйлдэх явдал байсан. Би хүүхэд насныхаа Японы тухай дурсамжаа санан дурссан. Одоогийн байдлаар хичээл заагаад хэдхэн өдөр болж байна. Оюутнууд маань чин сэтгэлээсээ ярилцаж байгаа. Япон хүний хувьд Монгол оюутнууд япон хэлийг сонирхон суралцаж буйд үнэхээрийн их баяртай байна. Япон улсыг сонирхдог хүмүүстэй харилцан ойлголцлоо гүнзгийрүүлж чадвал ард түмэн, улс орныг ойртуулж чадна гэдэгт итгэж байна. Цаашдаа Ази тивд япон хэлний боловсролыг дэмжигч болохыг хүсэж байна. Ийнхүү Монгол улсад амьдрах хугацаа хэдийгээр богинохон хэдий ч надад их таатай байна. Та бүхэндээ баярлалаа. Ийнхүү өөрийн сэтгэгдлээ өндөрлөө.

НИЙГАТАГИЙН ЭМ ЗҮЙН ИХ СУРГУУЛИЙН БАГШ,
ПРОФЕССОРУУД СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ
ДЭЭР ИРЖ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ

新潟薬科大学の教授らがモンゴル文化教育大学を訪問



左からオユニバーサル理事、牧原理事長
高久教授、小瀬教授

9 сарын 19-ний өдөр Нийгатагийн эм зүйн их сургуулийн багш профессорууд Соёл Эрдэм дээд сургуультай танилцаж, хоёр сургуулийн хамтын ажиллагаа, оюутан солилцооны талаар санал бодлоо солилцлоо.

Нийгата Эм Зүйн Их Сургууль нь 1977 онд Нийгата мужийн анхны дөрвөн жилийн хувийн их сургууль болон үүсгэн байгуулагдсан бөгөөд 46 жилийн түүхтэй, ололт амжилтаараа бахархдаг их сургууль юм. 2023 оны 4-р сард Анагаах ухааны технологийн факультетийн Клиник лабораторийн шинжлэх

ухааны тэнхим, Сувилахуйн факультетийн Сувилахуйн тэнхимийг, Эм зүйн факультетийн Эм зүйн шинжлэх ухааны тэнхим, Ахуй амьдралын шинжлэх ухааны тэнхимээ нээсэн. Ахуйн аж үйлдвэрлэлийн бизнесийн тэнхим, Ахуйн амьдралын шинжлэх ухааны факультет гэсэн 4 факультет, 5 тэнхим, ахисан түвшний 2 тэнхимтэй. Эрүүл, бие даасан нийгмийг бий болгохын тулд орон нутгийн иргэдтэй хамтран боловсрол олгох, эрүүл мэндийн шинжлэх ухаанд анхаарлаа хандуулж, найдвартай мэргэжилтэн бэлтгэхэд туслах өвөрмөц боловсролын хөтөлбөрүүдийг санал болгодог их сургууль юм.

Харин Соёл Эрдэм дээд сургуульд бид бүхэн 1993 оноос Монгол улс дахь япон хэлний боловсрол олгох үйлсэд хувь нэмрээ оруулж, 5 мэргэжлийн хөтөлбөртэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн энэ өдөр Соёл Эрдэм дээд сургууль болон Нийгата эм зүйн их сургуулийн оюутнууд богино хугацаанд харилцан суралцах боломжийн талаар санал солилцож, Нийгата мужийн давуу тал, сэтгэл татам зүйлийг олон оюутанд мэдрүүлэх боломжийн талаар ярилцлаа.



高久教授、小瀬教授による新潟薬科大学に関する紹介

9月19日、新潟薬科大学の教授陣がモンゴル文化教育大学を訪問し、両大学の協力関係や留学生交流の可能性について話し合いました。新潟薬科大学は、1977年（昭和52年）に新潟県で最初の4年制私立大学として開学し、46年の歴史と実績を誇る大学です。2023年4月には医療技術学部臨床検査学科と看護学部看護学科を開設し、これまでの薬学部薬学科、応用生命科学部応用生命科学科、生命産業ビジネス学科を加えて、現在は4学部5学科、大学院2研究科からなる「医療・健康系総合大学」として歩んでいます。大学は「信頼されるプロになる」ための特色ある教育プログラムを提供し、地域社会と協働した教

育・研究を通じて、「医療・健康を科学する」ことを柱に、健康で自立した社会の実現を目指しています。「ひと」と「地域」への貢献を大切にしたい取り組みを行っています。一方、モンゴル文化教育大学は1993年からモンゴルにおける日本語教育事業に全力を尽くし、モンゴルと日本の親善交流に大きな懸け橋として貢献しています。

この日は、モンゴル文化教育大学の学生が新潟薬科大学で短期留学できる可能性について意見を交換し、また、より多くの学生に新潟の魅力を実感してもらいたいとの話し合いが行われました。



在モンゴル日本人会懇親交流会が終わって
記念写真INウランバートル市 8月31日



懇親交流会

左の手前から(株)ライセンスアカデミー有田常務執行役員、松原営業統括本部長、城所元在モンゴル日本大使館特命全権大使、牧原理事長、浅海先生、ハシヤ日本担当 9月12日



ウランバートルで開催されたモンゴルの著名な詩人作家である「ナ・サインチョクト誕生110周年記念国際学術シンポジウムが終わったあとの懇親会手前の左からアイトル教授、フルバートル教授、パイトル教授、牧原理事長、内田准教授、岡田教授、田中教授、二本教授、チョロンバートル教授、ボンソグ教授 8月



在モンゴル日本大使館の次席近藤様の歓迎会兼ウランバートルJICA事務所田中伸一所長の送別会
2024年9月13日